

ГАДААД ВАЛЮТЫН АРИЛЖААНЫ МЭДЭЭ ГАРГАХ ЖУРАМ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1. Валютын зохицуулалтын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 7 дахь хэсгийн зохицуулалтын хүрээнд төгрөгийн гадаад валюттай харьцах ханшийн тооцоололд ашиглах зорилгоор гадаад валютын арилжааны мэдээг банкууд гаргах, түүнийг Монголбанк хүлээн авах, оролцогчдын эрх, үүргийг тодорхойлох, уг үйл ажиллагааг зохицуулж хяналт тавихад энэ журмын зорилго оршино.
- 1.2. Монголбанк банкуудын гадаад валютын арилжааны мэдээнд үндэслэн төгрөгийн гадаад валюттай харьцах ханшийг тооцож, олон нийтэд зарлана.
- 1.3. Энэ журмын 1.2-т заасан ханшийг дараа өдөр нягтлан бодох бүртгэлд хүчинтэй мөрдөнө.

ХОЁР. БАНК МЭДЭЭ ГАРГАХ

- 2.1 Банк нь өмнөх ажлын өдрийн 15:30 цагаас тухайн өдрийн 15:30 цагийн хооронд хийгдсэн дараах мэдээ, мэдээллийг дор дурдсан хавсралтын дагуу үнэн зөв бэлтгэж, тухайн өдрийн 16:00 цагаас өмнө Монголбанкны мөнгөний захын үйл ажиллагаа хариуцсан газарт “Монголбанкны банкны тайлангийн систем”-ээр хүргүүлнэ.
 - 2.1.1 ”Гадаад валютын спот арилжааны мэдээ”-г энэ журмын нэгдүгээр хавсралтын дагуу;
 - 2.1.2 “Тавин мянган ам.доллар болон түүнээс дээш дүнтэй гадаад валютын спот арилжааны мэдээ”-г энэ журмын хоёрдугаар хавсралтын дагуу;
 - 2.1.3 “Гадаад валютын үүсмэл хэрэгслийн арилжааны мэдээ”-г энэ журмын гуравдугаар хавсралтын дагуу.
- 2.2 Банкны сүлжээ, системд саатал гарсан тохиолдолд банк нь энэ журмын 2.1.1-2.1.3 дахь хэсэгт заасан мэдээ, мэдээллийг цахим шуудангаар, эсвэл эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, банкны тэмдгээр баталгаажсан албан бичгээр ирүүлнэ.
- 2.3 Байгалийн гамшиг, гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйлийн улмаас, эсхүл Монголбанкнаас зөвшөөрөл олгосон бусад нөхцөлд банк энэ журмын 2.1.1-2.1.3 дахь хэсэгт заасан мэдээ, мэдээллийг энэ журмын 2.1 болон 2.2-т заасан байдлаар хүргүүлэх боломжгүй болсон тохиолдолд Монголбанкны мөнгөний захын үйл ажиллагаа хариуцсан газраас өгсөн чиглэлийн дагуу холбогдох мэдээллийг бэлтгэн хүргүүлнэ.
- 2.4 Банк энэ журмын 2.2 болон 2.3 дахь хэсэгт заасны дагуу мэдээллийг бэлтгэн ирүүлэхдээ үүссэн нөхцөл байдлыг Монголбанканд урьдчилан мэдэгдэж, зөвшөөрөл авсан байна.
- 2.5 Банк энэ журмын 2.2 болон 2.3 дахь хэсэгт заасны дагуу мэдээллийг бэлтгэн, ирүүлсэн тохиолдолд холбогдох тайлбарыг ажлын 5 өдрийн дотор Монголбанкны мөнгөний захын үйл ажиллагаа хариуцсан газарт албан бичгээр хүргүүлнэ.
- 2.6 Банк энэ журмын 2.2 болон 2.3 дахь хэсэгт заасны дагуу мэдээллийг бэлтгэн, ирүүлсэн тохиолдолд банкны сүлжээ, системийн саатал засварлагдсан, байгалийн гамшиг, гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйлс, Монголбанкнаас харгалзан үзсэн бусад нөхцөл дуусгавар болсон даруйд энэ журмын 2.1.1-2.1.3 дахь хэсэгт заасан мэдээ мэдээллийг энэ журмын 2.1-д заасны дагуу бэлтгэн хүргүүлнэ.
- 2.7 Банк нь ирүүлсэн мэдээ, мэдээллийн үнэн зөв байдлыг бүрэн хариуцна.
- 2.8 Банк нь гадаад валютын арилжааны мэдээний үнэн зөв, бодитой байдлыг хариуцах хоёр ажилтны нэр, албан тушаал, цахим хаягийн мэдээллийг өөрчлөгдсөн тухай бүр

Монголбанкны мөнгөний захын үйл ажиллагаа хариуцсан газарт domex@mongolbank.mn цахим хаягаар мэдэгдэнэ.

2.9 Монголбанкнаас энэ журмын 4.3-т заасны дагуу холбогдох шалгалтыг хийж гүйцэтгэхэд болон шаардлагатай гэж үзсэн бусад тохиолдолд банк Монголбанкнаас шаардсан мэдээ, мэдээллийг тухай бүр гаргаж өгнө.

ГУРАВ. МОНГОЛБАНК МЭДЭЭ ХҮЛЭЭН АВАХ

3.1 Монголбанк нь дараах бүрэн эрхтэй:

3.1.1 Энэ журмын 2.1 дэх хэсэгт заасан мэдээллийг авах;

3.1.2 Энэ журмын 2 дахь хэсэгт заасан үүргээ банк биелүүлж буй эсэхэд хяналт тавих;

3.1.3 Энэ журмын заалтыг биелүүлээгүй банканд Валютын зохицуулалтын тухай хууль, Зөрчлийн тухай хууль болон холбогдох бусад хуульд заасан хяналт, хариуцлагыг ногдуулах;

3.2 Монголбанкны мөнгөний захын үйл ажиллагаа хариуцсан газар нь гадаад валютын арилжааны мэдээний үнэн зөв, бодитой байдлыг хариуцах үүрэг бүхий хоёр ажилтны нэр, албан тушаал, цахим хаягийн мэдээллийг тухайн банкнаас энэ журмын 2.8 дахь хэсэгт заасны дагуу хүлээн авч, мэдээллийн сан үүсгэн “Монголбанкны банкны тайлангийн систем”-д нэвтрэх хэрэглэгчийн эрх, нууц үгийг өгнө.

3.3 Монголбанк нь “Монголбанкны банкны тайлангийн систем”-ээр хүргүүлсэн мэдээлэл болон энэ журмын холбогдох заалтын дагуу Монголбанкны мэдээллийн санд бүртгэлтэй цахим хаяг, албан бичгээр ирүүлсэн мэдээллийг хүлээн зөвшөөрнө.

ДӨРӨВ. ХЯНАЛТ

4.1 Энэ журмын 2 дахь хэсэгт заасны дагуу ирүүлсэн мэдээ, мэдээллийн үнэн зөв, бодитой байдлыг уг мэдээ, мэдээллийг ирүүлсэн банк бүрэн хариуцна.

4.2 Энэ журамд заасан мэдээ, мэдээллийг банк хугацаанд нь үнэн зөв ирүүлээгүй тохиолдолд Монголбанк нь тухайн банканд Валютын зохицуулалтын тухай хууль болон холбогдох бусад хуульд заасны дагуу үүрэг өгөх буюу шаардлага тавина.

4.3 Энэ журмын заалтыг дараалан зөрчсөн, тавьсан шаардлага, арга хэмжээг авч хэрэгжүүлээгүй тохиолдолд тухайн банканд Монголбанкны хяналт, шалгалтын чиг үүрэг бүхий газар, шаардлагатай гэж үзвэл Монголбанкны мөнгөний захын үйл ажиллагаа хариуцсан газартай хамтран хяналт, шалгалт хийнэ.

4.4 Шалгалтын үр дүнг Монголбанкны удирдлагад танилцуулж, мэдээг ирүүлэхдээ хугацаа хоцроосон, энэ журмын дагуу ирүүлээгүй бол холбогдох хуульд заасан арга хэмжээг авна.

___оОо___

ГАДААД ВАЛЮТЫН СПОТ АРИЛЖААНЫ МЭДЭЭ

Мэдээний огноо	Хэлцэл хийгдсэн огноо	Банкны нэр	Харилцагчийн төрөл	Спот төрөл	Төрөл (Бэлэн/Бэлэн бус)	Гүйлгээ хийгдэх огноо	Худалдаж авсан валютын дүн	Валютын код	Ханш	Худалдсан валютын дүн	Валютын код	Тайлбар
			Монголбанк	Спот	Бэлэн							
			Бусад дотоодын банк		Бэлэн бус							
			Бусад гадаадын банк									
			Монгол Улсын Хөгжлийн Банк									
			Сангийн Яам									
			Дотоодын ААН Байгууллага									
			Гадаадын ААН Байгууллага									
			Дотоодын иргэн									
			Гадаадын иргэн									

Тайлбар:

- Голлох валют мөн эсэхээс үл хамаарч бүх төрлийн валютад холбогдох спот арилжааг мэдээлэх. Ингэхдээ биет алтны арилжааг валют арилжаанд хамааруулахгүй байх;
- "Мэдээний огноо", "Хэлцэл хийгдсэн огноо" болон "Эхний гүйлгээний огноо"-ны ялгааг сайтар анхаарч, үнэн зөв бөглөсөн байх;
- "Харилцагчийн төрөл", "Спот, своп, форвард төрөл", "Төрөл (Бэлэн/Бэлэн бус)" баганад өгөгдсөн сонголтуудаас өөр мэдээлэл оруулахгүй, өгөгдсөн сонголтуудын бичигдсэн хэлбэрийг өөрчлөхгүй байх;
- Спот хэлцлийн мэдээллийг тухайн хэлцэл хийгдсэн өдрийн мэдээнд ирүүлэх. Ингэхдээ хэлцэл тухайн өдрийн 15:30 цагаас хойш хийгдсэн бол журмын дагуу дараа өдрийн мэдээнд оруулах;
- Сонголтод байхгүй, өгөгдсөн загварын хүрээнд оруулах боломжгүй, хэлцлийн хүрээний чухал ач холбогдолтой мэдээллийг тайлбар хэсэгт бичих. Тодруулбал, буцаагдсан арилжааны мэдээллийг ирүүлэхдээ “Буцсан арилжаа”, төлбөр тооцоо хийгдэлгүй цуцлагдсан арилжааны мэдээллийг ирүүлэхдээ “Цуцлагдсан арилжаа” шүүхийн шийдвэрээр хийгдэж буй арилжааны хувьд “Шүүхийн шийдвэрээр”, харилцагчийн нэрийг нууцалсан зохицуулалт бүхий цахим талбарт арилжаа хийсэн тохиолдолд “Нэр нууцалсан” гэх зэргээр тайлбар оруулах;
- Валют арилжааны гүйлгээний шимтгэлийг спот болон үүсмэл хэлцэл байдлаар бүртгэхгүй байх;
- Монголбанк нь "Банкны тайлангийн систем"-ээр дамжуулан зөвхөн "Хянасан" төлөвтэй мэдээг хүлээн авна. "Хянасан" төлөвтэй мэдээнд банк засвар оруулах боломжгүй бөгөөд засвар оруулах шаардлагатай тохиолдолд тухай бүр Монголбанкны холбогдох ажилтанд мэдэгдэж, "Хянасан" төлөвийг цуцлуулах замаар мэдээллийг шинэчлэн оруулна.

50,000 АМ.ДОЛЛАР БОЛОН ТҮҮНЭЭС ДЭЭШ ДҮНТЭЙ ГАДААД ВАЛЮТЫН СПОТ АРИЛЖААНЫ МЭДЭЭ

Мэдээний огноо	Хэлцэл хийгдсэн огноо	Банкны нэр	Харилцагчийн төрөл	Харилцагчийн нэр	Регистрийн дугаар	Спот төрөл	Төрөл (Бэлэн/Бэлэн бус)	Гүйлгээ хийгдэх огноо	Худалдаж авсан валютын дүн	Валютын код	Ханш	Худалдсан валютын дүн	Валютын код	Тайлбар
			Монголбанк			Спот	Бэлэн							
			Бусад дотоодын банк				Бэлэн бус							
			Бусад гадаадын банк											
			Монгол Улсын Хөгжлийн Банк											
			Сангийн Яам											
			Дотоодын ААН Байгууллага											
			Гадаадын ААН Байгууллага											
			Дотоодын иргэн											
			Гадаадын иргэн											

Тайлбар:

- Голлох валют мөн эсэхээс үл хамаарч бүх төрлийн валютад холбогдох 50,000 ам.доллар (бусад валютын хувьд үүнтэй дүйцэх хэмжээний) болон түүнээс дээш дүнтэй спот арилжааг арилжаа нэг бүрээр мэдээлэх. Ингэхдээ биет алтны арилжааг валют арилжаанд хамааруулахгүй байх;
- "Мэдээний огноо", "Хэлцэл хийгдсэн огноо" болон "Эхний гүйлгээний огноо"-ны ялгааг сайтар анхаарч, үнэн зөв бөглөсөн байх;
- "Харилцагчийн төрөл", "Спот, своп, форвард төрөл", "Төрөл (Бэлэн/Бэлэн бус)" баганад өгөгдсөн сонголтуудаас өөр мэдээлэл оруулахгүй, өгөгдсөн сонголтуудын бичигдсэн хэлбэрийг өөрчлөхгүй байх;
- Спот хэлцлийн мэдээллийг тухайн хэлцэл хийгдсэн өдрийн мэдээнд ирүүлэх. Ингэхдээ хэлцэл тухайн өдрийн 15:30 цагаас хойш хийгдсэн бол журмын дагуу дараа өдрийн мэдээнд оруулах;
- Гадаад болон дотоодын иргэний хувьд тухайн иргэний овог нэрийг холбогдох иргэний үнэмлэх, гадаад паспорт дахь дараалал, бичиглэлийн дагуу, бүтэн, алдаагүй, зөв бичнэ. Харин гадаад болон дотоодын аж ахуйн нэгж байгууллагын нэрийг тухайн улсын бизнес регистрийн санд бүртгэлтэй нэрээр, алдаагүй зөв бичих;
- Дотоодын иргэний хувьд тухайн иргэний Улсын бүртгэлд бүртгэгдсэн регистрийн дугаар, гадаадын иргэний хувьд гадаад паспортын дугаар, гадаад болон дотоодын ААНБайгууллагын хувьд тухайн улсын бизнес регистрийн санд бүртгэлтэй регистрийн дугаар байх;
- Дотоодын иргэн, аж ахуйн нэгжийн овог, нэр, регистрийн дугаар нь “ХУР” төрийн мэдээлэл солилцооны систем дэх бүртгэлээс зөрөхгүй байх;
- Сонголтод байхгүй, өгөгдсөн загварын хүрээнд оруулах боломжгүй, хэлцлийн хүрээний чухал ач холбогдолтой мэдээллийг тайлбар хэсэгт бичих. Тодруулбал, буцаагдсан арилжааны мэдээллийг ирүүлэхдээ “Буцсан арилжаа”, төлбөр тооцоо хийгдэлгүй цуцлагдсан арилжааны мэдээллийг ирүүлэхдээ “Цуцлагдсан арилжаа”, шүүхийн шийдвэрээр хийгдэж буй арилжааны хувьд “Шүүхийн шийдвэрээр”, харилцагчийн нэрийг нууцалсан зохицуулалт бүхий цахим талбарт арилжаа хийсэн тохиолдолд “Нэр нууцалсан” гэх зэргээр тайлбар оруулах;
- Валют арилжааны гүйлгээний шимтгэлийг спот болон үүсмэл хэлцэл байдлаар бүртгэхгүй байх;
- Монголбанк нь "Банкны тайлангийн систем"-ээр дамжуулан зөвхөн "Хянасан" төлөвтэй мэдээг хүлээн авна. "Хянасан" төлөвтэй мэдээнд банк засвар оруулах боломжгүй бөгөөд засвар оруулах шаардлагатай тохиолдолд тухай бүр Монголбанкны холбогдох ажилтанд мэдэгдэж, "Хянасан" төлөвийг цуцлуулах замаар мэдээллийг шинэчлэн оруулна.

ГАДААД ВАЛЮТЫН ҮҮСМЭЛ ХЭРЭГСЛИЙН АРИЛЖААНЫ МЭДЭЭ

Мэдээний огноо	Хэлтэл хийгдсэн огноо	Банкны нэр	Харилцагчийн төрөл	Харилцагчийн нэр	Регистрийн дугаар	Спот, своп, форвард төрөл	Төрөл (Бэлэн/Бэлэн бус)	Эхний гүйлгээ хийгдэх огноо	Эхний гүйлгээгээр авсан валютын дүн	Эхний гүйлгээгээр авсан валютын код	Эхний гүйлгээний ханш	Эхний гүйлгээгээр зарсан валютын дүн	Эхний гүйлгээгээр зарсан валютын код	Форвард гүйлгээ хийгдэх огноо	Форвард гүйлгээгээр авсан валютын дүн	Форвард гүйлгээгээр авсан валютын код	Форвард ханш	Форвард гүйлгээгээр зарсан валютын дүн	Форвард гүйлгээгээр зарсан валютын код	Тайлбар
			Монголбанк			Своп	Бэлэн													
			Бусад дотоодын банк			Своп буцсан	Бэлэн бус													
			Бусад гадаадын банк			Форвард														
			Монгол Улсын Хөгжлийн Банк			Форвард биелсэн														
			Сангийн Яам			Бодит бус форвард														
			Дотоодын ААН Байгууллага			Бодит бус форвард биелсэн														
			Гадаадын ААН Байгууллага			Опшин														
			Дотоодын иргэн			Опшин биелсэн														
			Гадаадын иргэн			Бусад														

Тайлбар:

- Голлох валют мөн эсэхээс үл хамаарч бүх төрлийн валютад холбогдох 50,000 ам.доллар (бусад валютын хувьд үүнтэй дүйцэх хэмжээний) болон түүнээс дээш дүнтэй үүсмэл арилжааг арилжаа нэг бүрээр мэдээлэх. Ингэхдээ биет алтны арилжааг валют арилжаанд хамааруулахгүй байх;
- "Мэдээний огноо", "Хэлтэл хийгдсэн огноо" болон "Эхний гүйлгээний огноо" болон "Форвард гүйлгээний огноо"-ны ялгааг сайтар анхаарч, үнэн зөв бөглөсөн байх;
- "Харилцагчийн төрөл", "Спот, своп, форвард төрөл", "Төрөл (Бэлэн/Бэлэн бус)" баганад өгөгдсөн сонголтуудаас өөр мэдээлэл оруулахгүй, өгөгдсөн сонголтуудын бичигдсэн хэлбэрийг өөрчлөхгүй байх;
- "Своп", "Форвард", "Бодит бус форвард", "Опшин" төрлүүдийг тухайн хэлцэл хийгдсэн өдөр сонгож, холбогдох мэдээллүүдийг ирүүлэх;
- "Своп буцсан" гэсэн төрлийг своп хэлцлийн буцах гүйлгээ хийгдсэн өдөр сонгож, холбогдох мэдээллүүдийг ирүүлэх;
- Монголбанктай байгуулсан бодит бус урт хугацаат своп зэрэг зөвхөн эхний гүйлгээ хийгдэх своп хэлцлийн хувьд сүүлийн буюу "Своп буцсан" гүйлгээг тайлагнахгүй байх. Харин эхний гүйлгээг тайлагнахдаа "Своп" гэсэн төрлийг сонгож Тайлбар хэсэгт "Бодит бус своп" гэж нэмэлт тайлбар оруулах;
- "Форвард биелсэн", "Бодит бус форвард биелсэн", "Опшин биелсэн" төрлүүдийг форвард, опшин арилжаа биелсэн/хаасан өдөр сонгож, холбогдох мэдээг ирүүлэх;
- Гадаад болон дотоодын иргэний хувьд тухайн иргэний овог нэрийг холбогдох иргэний үнэмлэх, гадаад паспорт дахь дараалал, бичиглэлийн дагуу, бүтэн, алдаагүй, зөв бичнэ. Харин гадаад болон дотоодын аж ахуйн нэгж байгууллагын нэрийг тухайн улсын бизнес регистрийн санд бүртгэлтэй нэрээр, алдаагүй зөв бичих;
- Дотоодын иргэний хувьд тухайн иргэний Улсын бүртгэлд бүртгэгдсэн регистрийн дугаар, гадаадын иргэний хувьд гадаад паспортын дугаар, гадаад болон дотоодын ААНБайгууллагын хувьд тухайн улсын бизнес регистрийн санд бүртгэлтэй регистрийн дугаар байх;
- Дотоодын иргэн, аж ахуйн нэгжийн овог, нэр, регистрийн дугаар нь "ХУР" төрийн мэдээлэл солилцооны систем дэх бүртгэлээс зөрөхгүй байх;
- Сонголтод байхгүй, өгөгдсөн загварын хүрээнд оруулах боломжгүй, хэлцлийн хүрээний чухал ач холбогдолтой мэдээллийг тайлбар хэсэгт бичих. Тодруулбал, буцаагдсан арилжааны мэдээллийг ирүүлэхдээ "Буцсан арилжаа", төлбөр тооцоо хийгдэлгүй цуцлагдсан арилжааны мэдээллийг ирүүлэхдээ "Цуцлагдсан арилжаа", шүүхийн шийдвэрээр хийгдэж буй арилжааны хувьд "Шүүхийн шийдвэрээр", харилцагчийн нэрийг нууцалсан зохицуулалт бүхий цахим талбарт арилжаа хийсэн тохиолдолд "Нэр нууцалсан", үүсмэл хэлцлийн хүүний төлбөрийн мэдээллийг ирүүлэхдээ "Хүүний төлбөр" гэх зэргээр тайлбар оруулах;
- Валют арилжааны гүйлгээний шимтгэлийг спот болон үүсмэл хэлцэл байдлаар бүртгэхгүй байх;
- Монголбанк нь "Банкны тайлангийн систем"-ээр дамжуулан зөвхөн "Хянасан" төлөвтэй мэдээг хүлээн авна. "Хянасан" төлөвтэй мэдээнд банк засвар оруулах боломжгүй бөгөөд засвар оруулах шаардлагатай тохиолдолд тухай бүр Монголбанкны холбогдох ажилтанд мэдэгдэж, "Хянасан" төлөвийг цуцлуулах замаар мэдээллийг шинэчлэн оруулна.